



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2011 оны 5 сарын 23 өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

Г Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг  
ангилан ялгах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх,  
халдвартгүйтгэх, устгах заавар батлах тухай

Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор  
ТУШААХ НЬ:

- “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдвартгүйтгэх, устгах заавар”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлын бүртгэлийн маягт”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг тээвэрлэх заавар”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Энэхүү зааврыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн нэгдэл, улсын болон хувийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт даалгасугай.



САЙД

С. ЛАМБАА

080511

Эрүүл мэндийн сайдын 2011 оны  
5. сарын 12.ны өдрийн 158. дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт


**Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах,  
тээвэрлэх, халдвартгүйтгэх, устгах заавар**

**Нэг. Нэр томъёо, тодорхойлолт**

- 1.1. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент гэдэг нь хог хаягал үүссэн цэгээс түүнийг ангилах, ялгах, савлах, цуглуулах, хадгалах, түр байршуулах, тээвэрлэх, халдвартгүйтгэх, устгах, дахин боловсруулах үйл ажиллагаа юм.
- 1.2. Хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг, энэ чиглэлээр судалгаа, сургалт, үйлдвэрлэл, хяналтын ажил эрхэлдэг байгууллагуудад үүсэх хий, шингэн, хатуу хог хаягдлыг эрүүл мэндийн байгууллагын “**НИЙТ ХОГ ХАЯГДАЛ**” гэнэ.
- 1.3. Эрүүл мэндийн байгууллагын албан тасалгаа, үйлчилгээний өрөө, агуулах, хонгил, орчны эдэлбэр газарт үүсэх ахуйн хог хаягдлыг “**ЕРДИЙН ХОГ ХАЯГДАЛ**” гэнэ.
- 1.4. Эрүүл мэндийн байгууллагын оношлогоо, эмчилгээ, үйлчилгээний явцад үүсэх хүн, амьтны бие, эрхтэн, эд, хэсэг, бичил биетийн өсгөвөр, цус, бусад шингэн, ялгадас, эм, эмийн бүтээгдэхүүн, био бэлдмэл, зүү, тариур, хурц үзүүртэй, иртэй багаж хэрэгсэл, химийн болон цацраг идэвхт бодис зэрэг хог хаягдлыг “**ТУСГАЙ ХОГ ХАЯГДАЛ**” гэнэ.

**Хоёр. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилан ялгах үйл  
ажиллагаа**

Эрүүл мэндийн байгууллагаас үүсч буй нийт хог хаягдлыг ердийн болон тусгай гэж 2 ангилна (Бүдүүвч 1).



Бүдүүвч 1: Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын ангилал

## 2.1. Ердийн хог хаягдал

Ердийн хог хаягдлыг ахуйн болон дахин боловсруулах хог хаягдал гэж ангилна.

### 2.1.1. Ахуйн хог хаягдал

Ахуйн хог хаягдалд дараах төрлийн ердийн хог хаягдал хамаарна. Үүнд:

- Албан тасалгаа, үйлчилгээний өрөө, бие засах газар, гал тогоо, агуулах, хонгил, орчны эдэлбэр газар, цэцэрлэг, ногоон талбайгаас гарч буй сав баглаа боодол, хоол хүнс, жимсний хальс гэх мэт хог хаягдал орно.

## 2.1.2. Дахин боловсруулах хог хаягдал

Шил, цаас, цаасан хайрцаг, хөнгөн цагаан, хаягдал төмөр болон төрөл бүрийн хуванцар зэрэг ашиглаж болох хог хаягдал нь дахин боловсруулах хог хаягдалд хамаарна (Хүснэгт 1).

**Хүснэгт 1: Ердийн хог хаягдал**

<b>Өнгө</b>		<b>ХАР</b>
<b>Савлалт</b>		Хар өнгийн нийлэг уутанд хийнэ
<b>Таних тэмдэг</b>	Ахуйн хог хаядал	Тэмдэглэгээ, таних тэмдэг шаардлагагүй
	Дахин боловсруулах хог хаягдал	 <p>Цувраа 3 сум бүхий дахин боловсруулалтын олон улсын таних тэмдгийг хогийн сав, уутны гадна талд байрлуулна</p>
<b>Хаяглалт</b>		Жирийн үед хаяглах шаардлагагүй бөгөөд зарим төрлийн судалгаа шинжилгээний үед хог хаягдал үүсч буй тасаг, хэлтэс, ажилтны нэр зэргийг бичнэ.

## 2.2. Тусгай хог хаягдал

### 2.2.1. Халдвартын зэрэг өндөртэй хог хаягдал

Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД)-ээр зохицуулагддаг болон байгалийн голомтот халдварт өвчинүүд, сурьеэ, бэлгийн замын халдварт өвчинүүдийн үед болон лабораториос үүсэх хог хаягдууд (эд эсийн өсгөвөр дэх эмгэг төрөгч агуулсан амьд үүсгэгч, тэжээлт орчин, тэдгээрийг хэрэглэхэд ашиглагдаж буй багаж хэрэгсэл) халдвартын зэрэг өндөртэй хог хаягдалд хамаарна (Хүснэгт 2).

**Хүснэгт 2: Халдвартын зэрэглэл өндөртэй хог хаягдал**

<b>Өнгө</b>		<b>ХАР</b>
<b>Савлалт</b>		Шингэн нэвчдэггүй, бат бөх улаан өнгийн уутанд хийнэ.
<b>Таних тэмдэг</b>		Биоаюулгүйн таних тэмдэг бүхий гурвалжин таних тэмдгийг хогийн сав, уутны гадна талд байрлуулна
<b>Хаяглалт</b>		▪ Тасаг, нэгжийн нэр

- |  |   |
|--|---|
|  | <ul style="list-style-type: none"> <li>▪ Хог хаягдал үүссэн огноо</li> <li>▪ Хог хаягдлын хэмжээ</li> </ul> |
|--|---|

### 2.2.2. Халдвартай хог хаягдал

Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад үүсэх халдварын эрсдэл бүхий биеийн өтгөн, шингэн ялгадас, цус, цэр, шүлс, г.м.-ээр бохирлогдсон зүйлс; арьс, салстыг арчиж цэвэрлэх, эмчилгээ үйлчилгээнд хэрэглэсэн цаас, самбай, хөвөн, даавуу г.м. боолтын материал; нэг удаагийн хуванцар багаж хэрэгсэл, гуурс, толь, бээлий, систем, малгай, амны хаалт, хуучирсан цагаан хэрэглэл болон бусад хог хаягдууд нь халдвартай хог хаягдалд хамаарна (Хүснэгт 3).

**Хүснэгт 3: Халдвартай хог хаягдал**

Өнгө	ШАР	
Савлалт	Шингэн нэвчдэггүй, бат бөх шар өнгийн уутанд хийнэ.	
Таних тэмдэг		Биоаюулгүйн таних тэмдэг бүхий гурвалжин таних тэмдгийг хогийн сав, уутны гадна талд байрлуулна
Хаяглалт	<ul style="list-style-type: none"> <li>▪ Тасаг, нэгжийн нэр</li> <li>▪ Хог хаягдал үүссэн огноо</li> <li>▪ Хог хаягдлын хэмжээ</li> </ul>	

### 2.2.3. Хурц үзүүртэй, иртэй хог хаягдал

**Хүснэгт 4: Хурц үзүүртэй, иртэй хог хаягдал**

Өнгө	ШАР	
Савлалт	Үс нэвчдэггүй, цоорч гэмтдэггүй, таглаатай, зориулалтын хатуу цаасан аюулгүйн хайрцагт цуглнуулна. Зүү мултлагчтай хуванцар эдээр хийсэн аюулгүй хайрцаг эсвэл зүү тайрагч, шатаагч, хэрэглэсэн тохиолдолд тариурын арталын хуванцыг шар өнгийн халдвартай хог хаягдлын уутанд хийнэ.	
Таних тэмдэг		Биоаюулгүйн таних тэмдэг бүхий гурвалжин таних тэмдгийг хогийн сав, уутны гадна талд байрлуулна
Хаяглалт	<ul style="list-style-type: none"> <li>▪ “ЭНЭ ТҮВШНЭЭС ХЭТРҮҮЛЭН ДҮҮРГЭХИЙГ ХОРИГЛОНО” гэсэн анхааруулгыг хайрцагны гадна талын 2/3 хэсэгт байрлуулна.</li> </ul>	

- |  |   |
|--|---|
|  | <ul style="list-style-type: none"> <li>▪ Тасаг, нэгжийн нэр</li> <li>▪ Хог хаягдал үүссэн огноо</li> <li>▪ Хог хаягдлын хэмжээ</li> </ul> |
|--|---|

#### 2.2.4. Эмгэг хог хаягдал

Мэс ажилбар, задлан шинжилгээний явцад гарсан биеийн хэсэг, тайрсан эд эрхтэн, хавдрын ургацаг, эхэс, зулбадас гэх мэт хог хаягдал эмгэг хог хаягдалд хамаарна (Хүснэгт 5).


**Хүснэгт 5: Эмгэг хог хаягдал**

Өнгө	Шар
Савлалт	Шингэн нэвчдэггүй, бат бөх шар өнгийн уутанд хийнэ.
Таних тэмдэг	Таних тэмдэг шаардлагагүй
Хаяглалт	<p>“Эмгэг хог хаягдал – болгоомжтой харьцана уу” гэсэн анхааруулгыг уутны гадна талд байрлуулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Тасаг, нэгжийн нэр</li> <li>▪ Хог хаягдал үүссэн огноо</li> <li>▪ Хог хаягдлын хэмжээ</li> </ul>

#### 2.2.5. Эмийн хог хаягдал

Хугацаа дууссан, хэрэглэхийг хориглосон, хагарч гэмтсэн, бохирдсон эм, биобэлдмэл, вакцин, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодис агуулсан сав, тун шил, хайрцаг гэх мэт хог хаягдал эмийн хог хаягдалд хамаарна (Хүснэгт 6).

**Хүснэгт 6: Эмийн хог хаягдал**

Өнгө	ХҮРЭН
Савлалт	Шингэн нэвчдэггүй, бат бөх хүрэн өнгийн уутанд хийнэ.
Таних тэмдэг	<p>Хог хаягдлын шинж чанар, төрлөөс хамааруулан хортой, зэврэмтгий, исэл, шатамхай, холимог аюултай, хүрээлэн буй орчныг бохирдуулах материал г.м. тохирох таних тэмдэгтэй байна.</p>  <p> маш хортой      хортой      хөнөөлтэй      цочроогч      идэмхий</p>

	исэлдүүлэгч	маш шатамхай	өндөр шатамхай	тэсрээмтгий	байгаль орчинд хортой
Хаяглалт	<ul style="list-style-type: none"> <li>▪ Тасаг, нэгжийн нэр</li> <li>▪ Хог хаягдал үүссэн огноо</li> <li>▪ Хог хаягдлын хэмжээ</li> </ul>				

#### 2.4.6. Химийн бодисын хог хаягдал

Эрүүл мэндийн байгууллагын оношилгоо эмчилгээ, шинжилгээ, судалгаа, цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгал, халдвартгүйтгэлийн үйл ажиллагааны явцад үүссэн хатуу, шингэн, хийн байдалтай лабораторийн хаягдал (урвалж оношлуур, химийн бодисын хаягдал г.м.), ариутгалын бодис, уусгач, рентген зургийн хальс бэхжүүлэх, боловсруулах уусмал, формальдегид, этилен оксид, хугацаа дууссан химийн бодисууд гэх мэт хог хаягдал нь химийн бодисын хог хаягдалд хамаарна (Хүснэгт 7).

Хүснэгт 7: Химийн бодисын хог хаягдал

Өнгө	XURЭН
Савалт	Зөөх, тээвэрлэх нөхцлийг хангасан түгжээтэй, бат бөх багтаамжтай хүрэн өнгийн саванд хийнэ. Өөр өөр төрлийн химийн бодисын хог хаягдлыг хольж болохгүй.
Таних тэмдэг	Хог хаягдлын шинж чанар, төрлөөс хамааруулан хортой, зэврээмтгий, исэл, шатамхай, холимог аюултай, хүрээлэн буй орчныг бохирдуулах материал г.м. тохирох таних тэмдэгтэй байна.

маш хортой                    хортой                    хөнөөлтэй                    цочроогч                    идэмхий

исэлдүүлэгч                    маш шатамхай                    өндөр шатамхай                    тэсрээмтгий                    байгаль орчинд хортой

<b>Хаяглалт</b>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Тасаг, нэгжийн нэр</li> <li>▪ Хог хаягдал үүссэн огноо</li> <li>▪ Хог хаягдлын хэмжээ</li> </ul>
-----------------	---

### 2.2.7. Эсэд хортой нөлөөтэй хог хаягдал

Хавдрын эмчилгээний үед хэрэглэгддэг эсэд хортой нөлөө үзүүлдэг эм, эмийн үлдэгдэл, тэдгээрийг агуулж байсан сав, тун шил, хайрцаг, хавдрын эмчилгээ хийлгэсэн хүний биологийн шингэн гэх мэт хог хаягдал нь эсэд хортой нөлөөтэй хог хаягдалд хамаарна (Хүснэгт 8).

**Хүснэгт 8 : Эсэд хортой нөлөөтэй хог хаягдал**

<b>Өнгө</b>	
<b>Савлалт</b>	Зөөх, тээвэрлэх нөхцлийг хангасан, түгжээтэй, бат бөх, багтаамжтай хүрэн өнгийн саванд хийнэ.
<b>Таних тэмдэг</b>	 Телофазын үеийн эсийн хуваагдлыг харуулсан таних тэмдэгтэй байна.
<b>Хаяглалт</b>	"Эсэд хортой нөлөөтэй хог хаягдал" гэсэн анхааруулгыг савны гадна талд байрлуулна. <ul style="list-style-type: none"> <li>▪ Тасаг, нэгжийн нэр</li> <li>▪ Хог хаягдал үүссэн огноо</li> <li>▪ Хог хаягдлын хэмжээ</li> </ul>

### 2.2.8. Цацраг идэвхит хог хаягдал

Эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, судалгааны ажлын явцад үүсэх Cr-51, Ga-67, I-25, I-131, In-111, P-32, Rb-86, RD-222, S-35, Tc-99m гэх мэт ионжуулагч цацраг бүхий радионуклидууд агуулсан цацраг идэвхит шинж чанар бүхий хатуу, шингэн, хийн хаягдал нь цацраг идэвхит хог хаягдалд хамаарна (Хүснэгт 9).

### Хүснэгт 9: Цацраг идэвхит хог хаягдал

<b>Савлалт</b>	Зөөх, тээвэрлэх нөхцлийг хангасан, түгжээтэй, бат бөх тугалган хамгаалалт бүхий зориулалтын саванд хийнэ.	
<b>Таних тэмдэг</b>		Олон улсын цацрагийн таних тэмдэгтэй байна.
<b>Хаяглалт</b>	<p>“Анхаар! Цацраг идэвхит хог хаягдал” гэсэн анхааруулгыг савны гадна талд байрлуулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Цацраг идэвхит бодисын төрөл</li> <li>▪ Тухайн өдрийн цацраг идэвхи (хадгалж эхэлсэн хугацаа)</li> <li>▪ Хадгалах шаардлагатай хугацаа</li> <li>▪ Аюулгүй ажиллагааны заавар</li> <li>▪ Хог хаягдлын хэмжээ</li> </ul>	

#### 2.2.9. Даралтат сав

Шахсан хий, шингэн, нунтаг материал агуулсан бортогон хэлбэртэй цилиндр эсвэл аэрозольтой савнууд даралтат саванд хамаарна. Даралтат савыг босоо байрлалд хадгална.

#### 2.2.10.Хүнд металлын хог хаягдал

Хэрэглээнээс гарсан халууны шил, даралтны аппарат г.м. эмнэлгийн зарим төрлийн багаж хэрэгсэл, өдрийн гэрэл, зайд нь хүнд металл, тухайлбал кадьми, мөнгөн ус, хар тугалга г.м. агуулдаг тул эдгээр хог хаягдал нь хүнд металлын хог хаягдалд хамаарна (Хүснэгт 10).

### Хүснэгт 10: Хүнд металлын хог хаягдал

<b>Савлалт</b>	Зөөх, тээвэрлэх нөхцлийг хангасан түгжээтэй, бат бөх саванд хийнэ. Химийн бодисын хог хаягдалтай хольж болохгүй.	
<b>Таних тэмдэг</b>		Араг яс бүхий олон улсын таних тэмдэгтэй байна.
<b>Хаяглалт</b>	<p>“Хүнд металлын хог хаягдал” гэсэн анхааруулгыг савны гадна талд байрлуулна.</p>	

- |  |   |
|--|---|
|  | <ul style="list-style-type: none"> <li>▪ Тасаг, нэгжийн нэр</li> <li>▪ Хог хаягдлын ангилал, хог хаягдал гарсан огноо</li> <li>▪ Хог хаягдлын хэмжээ</li> </ul> |
|--|---|

### **2.3. Хогийн уут, саванд тавигдах шаардлага**

#### **2.3.1. Хог хаягдлын уут дараах шаардлага хангасан байна.**

1. Амархан цоорч гэмтэхгүй, шингэн нэвчихгүй, нийлэг материалыаар хийгдсэн, 5 микреноос багагүй зузаантай уутыг ашиглана.
2. Хог хаягдлын уут тус бүрийн ангилалд тохирсон өнгөтэй байх бөгөөд тохирох таних тэмдэг, тэмдэглэгээг байрлуулсан байна.


#### **2.3.2. Хогийн сав, уут тогтоогч дараах шаардлага хангасан байна.**

1. Зориулалтын хогийн сав эсвэл уут тогтоогчийг ашиглана.
2. Хогийн сав нь шингэн нэвчихгүй, хуванцар, металл зэрэг материалыаар хийгдсэн зузаан, бат бөх байна.
3. Хогийн сав нь таглаатай, хөлөөрөө дарж онгойлгодог байна.
4. Уут тогтоогч нь өндөр нягтралтай хуванцар материалыаар хийгдсэн, таглаатай байх бөгөөд хэрэв овор ихтэй бол дугуйтай байна.
5. Гарч байгаа хаягдлын хэмжээнээс хамаарч хогийн сав, уут тогтоогчийн багтаамж нь 10 – 250 л байх бөгөөд 2/3 – т “Анхаар” гэсэн тэмдэглэгээ байна.
6. Хогийн сав, уут тогтоогч нь био аюулгүйн тэмдэг тэмдэглэгээтэй байна.

#### **2.3.3. Хог хаягдалтай уут, савыг тодорхой нэг газар байршуулж, хаягдлыг ангилан ялгах талаар заавар, санамжийг бичиж тавьсан байна.**

#### **1 урав. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, зөөвөрлөх, түр байршуулах, тээвэрлэх үйл ажиллагаа**

- 3.1. Ангилан ялгасан хог хаягдлыг эмнэлэг дотор цуглуулах, зөөвөрлөх үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална (Бүдүүвч 2).



### Бүдүүвч 2: Хог хаягдал (х.х.)-ыг эмнэлэг дотор цуглуулах, зөөвөрлөх үйл ажиллагаа

- 3.2. Тасаг доторх хог цуглуулах цэгээс эмнэлгийн хог хаягдлыг түр хадгалах байр руу хог хаягдлыг зөөвөрлөх тэргэнцэр, сав нь дараах шаардлага хангасан байна:
- Ачиж, буулгах хялбар байх
  - Хог хаягдалтай уутыг гэмтээхээр хурц ирмэг, үзүүргүй байх
  - Таглаатай, тэмдэглэгээтэй
  - Түгээмэл хэрэглэгддэг угаалга цэвэрлэгээ, халдвартгүйтгэлийн бодист тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар материалыар хийгдсэн байх
  - Хэт өндөр биш байх

3.3. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг эмнэлэг дотор зөөвөрлөх хамгийн оновчтой маршрутыг байгууллага бүр тогтоосон байна. Ингэхдээ хог хаягдлын хэмжээ, төрөл, тасаг доторх цуглуулах цэгийн байршил, багтаамж, зөөвөрлөх тэргэнцрийн хүрэлцээ, үйлчлүүлэгчдийн нягтрал зэргийг тооцоолсон байна.

### 4. Эмнэлгийн хог хаягдлыг түр хадгалах байранд тавигдах шаардлага

4.1. Эрүүл мэндийн байгууллага бүрт эмнэлгийн хог хаягдлыг түр хадгалах байр байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хана, тааз, шалыг угааж цэвэрлэх, халдвартгүйтгэх боломжтой байх,
- Ус, бохир усны системийн холболттой, шал нь бохир ус зайлцуулах хоолойтой байх,
- Эмнэлэг дотроо эсвэл тусдаа байранд байрлаж тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх зам талбайгаар хангагдсан байх,

- Хаалга нь цоожтой, гадны хүн болон шувуу, бусад амьтан орох боломжгүй байх,
- Шаардлагатай хэрэгслээр хангагдсан байх (хоргуйжүүлэх, саармагжуулах бодис, уусмал, цэвэрлэгээний материал, хөргөх төхөөрөмж г.м.)
- Нарны шууд тусгал тусахгүй, сэргүн ( $18^{\circ}$  С хүртэл, 60%-иас ихгүй чийглэгтэй), агааржуулалт сайтай байх
- Байгалийн эсвэл зохиомол гэрэлтүүлэг хүрэлцээтэй байх,
- Аюулгүй ажиллагааны зааварчилгаатай байх (шингэн асгарсан тохиолдолд авах арга хэмжээ болон цус, биеийн шингэнтэй ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа г.м.),
- Хог хаягдлыг жинлэх зориулалттай жинтэй байх, бүртгэл хөтлөх,
- Боловсруулалтын арга өөр өөр хог хаягдал (химийн, цацраг идэвхит бодис, халдвартай г.м.) ялгаж хадгалах боломжтой байх бөгөөд агаар дахь хорт бодисуудын агууламж эрүүл ахуйн шаардлага хангасан байна.
- Хогийн сав, хог тээвэрлэх тэргэнцрийг цэвэр болон бохироор тусад нь хадгалах боломжтой байх,
- Гадна талдаа “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг түр хадгалах байр” тэмдэглэгээтэй, дараах таних тэмдэгтэй байх (Зураг 1).

		
Түр хадгалах байранд гадны хүн орохыг хориглоно	Халдвартай болон хурц үзүүртэй, иртэй хог хаягдлын био аюулгүйн таних тэмдэг	Химийн бодис болон эмийн хог хаягдлын таних тэмдэг

Зураг 1. Түр хадгалах байрны гадна талын таних тэмдэг

- Дотор талдаа дараах таних тэмдэгтэй байна (Зураг 2).

	
Хоол идэх, уухыг хориглоно	Тамхи татахыг хориглоно

Зураг 2. Түр хадгалах байрны дотор талын таних тэмдэг

4.2. Түр хадгалах байранд хог хаягдлыг эмнэлэг дотор зөөвөрлөх тэргэнцэр, ууттай хог хаягдлыг хадгалах зориулалтын том хэмжээтэй хогийн савтай байх гөөд эдгээрт байнгын болон урсгал засвар үйлчилгээ тогтмол хийнэ.

## 5. Хог хаягдлын тээвэрлэлт

5.1. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг эмнэлгээс гадагш тээвэрлэхэд энэхүү зааврын гуравдугаар хавсралтад заасан зааврыг мөрдөнө.

5.2. Эмнэлгийн хог хаягдлыг долоо хоногт 3-аас доошгүй удаа тээвэрлэн зайлуулна.

### Дөрөв. Хог хаягдлыг устгал

4.1. Эрүүл мэндийн байгууллагаас гарсан ердийн хог хаягдлыг тухайн орон нутгийн тохижилт үйлчилгээний байгууллагуудтай хийсэн гэрээний дагуу устгана.

4.2. Эрүүл мэндийн байгууллагад үүссэн тусгай хог хаягдлыг халдвартгүйтгэж устгахад дараах аргуудын аль нэгийг хэрэглэнэ.

- Өндөр даралттай уураар халдвартгүйтгэх
- Бичил долгиноор халдвартгүйтгэх
- Зориулалтын шатаах зууханд өндөр температурт шатаах ( $1100^{\circ}\text{C}$ -аас дээш температур)
- Эрүүл ахуйн шаардлага хангасан булах цэг (ландфилл)-т хаяж, өдөр тутам хөрсөөр хучих
- Булах, булшлах

4.3. Тусгай хог хаягдлыг ангилал тус бүрт тохирсон дараах аргаар устгана.

#### 4.3.1. Халдвартай болон хурц үзүүртэй, иртэй хог хаягдлыг устгал

Халдвартай хог хаягдлыг шар уутанд, хурц үзүүртэй, иртэй хог хаягдлыг аюулгүйн хайрцагт тус тус цуглуулж автоклавт  $105^{\circ}\text{C}$ -ийн температурт 30-аас багагүй,  $121^{\circ}\text{C}$ -ийн температурт 20-оос багагүй эсвэл  $134^{\circ}\text{C}$ -ийн температурт 10-аас багагүй минутын хугацаанд халдвартгүйтгэсний дараа боломжтой бол буталж, боломжгүй бол бутлалгүйгээр ландфилд булж устгана.

Хурц үзүүртэй, иртэй хог хаягдлыг зайлуулахад зүү шатаагч, зүү хугалагч багаж хэрэгсэл хэрэглэж болох бөгөөд хэрэглэсэн тохиолдолд зүүг шатааж эсвэл хугалж тариурын ар талын хуванцрыг халдвартай хог хаягдлын адилаар шар уутанд цуглуулан дээрхтэй адил аргаар халдвартгүйтгэсний дараа ландфилд дарж булна.

Ариутгалын чанарыг шалгахдаа химийн индикаторыг ариутгал болгонд, харин биологийн индикаторыг сард нэг удаа ашиглана.

#### **4.3.2. Халдварын зэрэг өндөртэй хог хаягдлыг устгал**

Халдварын зэрэг өндөртэй хог хаягдлыг үүссэн цэгт буюу тухайн байгууллагын тасаг, нэгжид урьдчилан химиин аргаар эсвэл өндөр даралттай уураар урьдчилан халдвартгүйтгэсний дараа бохир усны шугам, шаардлага хангасан бохирын цооногт нийлүүлэх бөгөөд эсвэл халдвартай хог хаягдлын адил устгана.

#### **4.3.3. Эмгэг хог хаягдлыг устгал**

Хэрэв эмгэг хог хаягдал нь жижиг хэмжээтэй, танигдахааргүй байвал халдвартай хог хаягдлын адилаар устгана. Бусад эмгэг хог хаягдлыг шатаана. Шаардлага хангасан шатаах зуух байхгүй тохиолдолд булах эсвэл ихсийн нүхэнд хийх зэрэг аргаар устгана. Ихсийн нүхийг хөдөө орон нутагт ашиглана.

#### **4.3.4. Эмийн хог хаягдлыг устгал**

Эмийн тусгай хог хаягдлыг үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, хандивлагчид эргүүлэн буцаах эсвэл өндөр хэмд шатаах зууханд шатаах аргаар устгана. Эмийн хог хаягдлыг блистер, лонх, хуванцар сав, уутнаас нь гаргалгүйгээр зөвхөн гаднах хайрцаг, баглаа боодлоос нь салгаж хуванцар, ган эсвэл төмөр бортогон дотор хийж түүн дотроо 75 хувьд нь хатуу ба хагас хатуу эм хийж үлдсэн хэсэгт нь цемент, шохойн холимог, элс зэргээр чигжиж (хаягдал 65 хувь, шохой 15 хувь, цемэнт 15 хувь, ус 5 хувь тус тус байна), бүрхүүлдсэний дараа булна.

Хор багатай буюу хоргүй шингэн амин дэм, төрөл бүрийн концентрацтай, аюулгүй шингэнүүд болох давс, амин хүчил, глюкоз, өөх тос зэрэг шингэн эм, эмийн цийлийг шингэлэн бохир усны шугам эсвэл шаардлага хангасан бохирын цооногт хийнэ. Хор багатай буюу хоргүй капсул, шахмал, мөхлөг, тарилгын нунтаг, хольц, тос, лосьон, гель, лаа гэх мэт хатуу, хагас хатуу хэлбэртэй эм, эмийн хог хаягдлыг гаднах боодлоос нь салгаж бутлагчаар буталж жижиглэсний дараагаар ахуйн хог хаягдлын цэгт хаях эсвэл булна.

Хортой эм, бодис агуулсан туншилыг хатуу, шингэн нэвчдэггүй гадаргуу эсвэл металл бортого, саванд хийж бат бөх модон тайрдас эсвэл алхаар бяцалж хагарсан шилнүүдийг цуглуулан хурц иртэй зүйл хадгалах боломжтой саванд хийж лацдан газарт шууд булж устгана. Туншилыг шатаахад дэлбэрэх, шатаах зуухыг гэмтээх боломжтой тул шатааж болохгүй.

Эсэд хортой нөлөөтэй эмийн хог хаягдлыг ханган нийлүүлэгчид нь буцааж өгөх, эсвэл зориулалтын шатаах зууханд өндөр хэмд шатааж устгана.

#### **4.3.5. Химиин бодисын хог хаягдлыг устгал**

Рентген зураг авахад ашигласан бэхжүүлэгч уусмалыг түр хадгалж дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлнэ

Химиин бодисын хог хаягдлыг түр хадгалах зориулалтын байранд аюулгүйгээр хадгалж, аюултай хог хаягдлын нэгдсэн байгууламжид хүлээлгэн өгнө.

#### **4.3.6. Эсэд хортой нөлөөтэй хог хаягдлыг устгал**

Эсэд хортой нөлөөтэй эмийн хог хаягдлыг үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, индивлагчид буцаах эсвэл 2 тасалгаатай өндөр хэмд шатдаг зориулалтын шатаах зууханд шатаана. Эдгээр эмийг шууд газарт булах, бохир усны шугам хоолойд хийх, туншилыг бяцлахыг хориглоно. Эмийг бортогоны эзэлхүүний 50 хувьд нь хийгээд цемент, шохой, усыг 15:15:5 харьцаатайгаар сайтар хольж дүүргэн бортогыг гагнаж лацдан 7-28 өдөр орхино. Хатаж, бэхжиж, хөдөлгөөнгүй болсон бортогыг газарт булж, дээрээс нь шингэн нэвчихгүй шавар давхарга хийнэ.

#### **4.3.7. Цацраг идэвхит хог хаягдлыг устгал**

Цацраг идэвхит хаягдлыг Монгол улсын “Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль” болон холбогдох дүрэм, зааварт заасны дагуу устгана.

#### **4.3.8. Даралтат савыг устгал**

Даралтат сав нь тэсрэх аюултай тул аюултай хог хаягдалтай хольж уураар халдваргүйтгэж, шатааж болохгүй. Инертийн хий, аюултай бодис агуулсан сав шатах эсвэл цоорох тохиолдолд дэлбэрэх эрсдэлтэй байдаг тул тусад нь цуглуулж дахин ашиглах эсвэл үйлдвэрлэгчид эргүүлэн нийлүүлнэ.

#### **4.3.9. Хүнд металлын хог хаягдлыг устгал**

Хүнд металлын хог хаягдлыг түр хадгалах байранд хадгалж аюултай хог хаягдлын нэгдсэн байгууламжид хүлээлгэн өгнө.

#### **4.3.10. Шингэн хог хаягдал зайлцуулалт**

Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж нь төвлөрсөн буюу хэсгийн бохир ус зайлцуулах шугамд холбогдсон бол хаягдлыг урьдчилан хоргуйжүүлж, саармагжуулж халдваргүйтгэсний дараа шугамд нийлүүлнэ.

Хэрэв бохир ус зайлцуулах шугамд холбогдоогүй бол бие засах газар, бохирын цооног нь хөрс, газрын доорхи усыг бохирдуулахгүй эрүүл ахуйн шаардлага хангасан байх бөгөөд тэдгээрийг тогтмол хугацаанд халдваргүйтгэх шаардлагатай.

Халдвартай шингэн ялгадсыг халдваргүйтгэхийн тулд гипохлорид кальци 1:5 хэмжээтэй хийж 1 цаг, 3 – 5 хувийн хлорамин “Б” 2:1 хэмжээтэй хийж 1 – 2 цаг байлгана. Өтгөн ялгадасыг 1 литрт 400 грамм хлорын шохой байхаар тооцож, 2 цаг байлгаж халдваргүйтгэнэ.

Хаягдлыг химийн аргаар халдваргүйтгэхэд эрх бүхий байгууллагаас зөвшөөрөгдсөн бодисыг зохих заавар журмын дагуу хэрэглэнэ.

Эрүүл мэндийн сайдын 2011 оны  
сарын 05. нөдрийн дугаар  
тушаалын хоёрдуга хавсралт

### Хүснэгт 1: Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын бүртгэлийн маягт

Тасгийн нэр.....

Огноо	
Шар ууттай хог	
Улаан ууттай хог	
Аюулгүйн хайрцаг	
Хүрэн ууттай хог	
Дараалтат сав	
Хүнд металлын хог хаягдал	
Цацраг идэвхит хог хаягдал	
Түр хадгалах байр руу явуулсан цаг	
Хүлээлтэн өгсөн хүний нэр, гарын үсэг	
Хүлээн авсан хүний нэр, гарын үсэг	

**Хүснэгт 2:** Эрүүл мэндийн байгууллын тусгай хог хаягдлын буртгэлийн мэдлэг

БАЛЫУНДАГЫ НЭР.....

Хог ачиж тээвэрлэсэн огноо	Хог хаягдлын жин /кг/				Хогны тээвэрлэлт, устгалын байгууллага	Хогны тээвэрлэлт, устгалын байгууллага
	Шар уттай хог	Улаан уттай хог	Аюулгүйн хайрцааг хог	Хүрэн уттай хог		

**Хүснэгт 3:** Эрүүл мэндийн байгууллагын халдварын зэрэг өндөртэй хог хаягдлын устгалын бүтэглийн маяг

Байгууллагын нэр..

Хүснэгт 4: Эрүүл мэндийн байгууллагын тус дай хаягдлыг нэгдсэн байгууламжид үргэлж маягт

Хог хаягдал ирсэн:	Гарын үсэг	Хог хаягдлын уурын халдвартгийгэл	Хог хаягдлын шатаах зууханд шатаалт	Үсэг aknijtphl raphi
			Улаатат phin xam	
			Orhoo	
		XanTbapprynt3n Xnig3h aknijtphl raphi Үсэг		
		NhAnkatoP Gnogorinnh/ /ximninnh,		
		Apnytrarphih ropm		
		Orhoo		
		Xyru33nraH abcah		
		Xyru33nraH ercех		
		Intp/ Xemkex /umpxer,		
		Ganryjnarphih h3p 3pvyrn mewAnnnh		
		Orhoo, Uar		

Эрүүл мэндийн сайдын 2011 оны  
5. сарын 23-ны өдрийн 15.8. дугаар  
тушаалын гуравдугаар хавсралт

### Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг тээвэрлэх заавар

#### Нэг. Ерөнхий зүйл

1. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг баглах, хаяглах, зам талбайгаар тээвэрлэхэд энэхүү зааврыг мөрдөнө.
2. Эрүүл мэндийн байгууллагын ахуйн хог хаягдлыг тээвэрлэх болон тусгай хог хаягдлыг шуудан, агаар, усан замаар тээвэрлэхэд энэхүү заавар хамаарахгүй бөгөөд тэдгээр нь олон улс болон дотоодод мөрдөгдөж буй дүрэм, заавраар зохицуулагдана.

#### Хоёр. Хог хаягдлыг баглах, хаяглах

- 2.1. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг тээвэрлэх нөхцөл, замын чичиргээ, температурын өөрчлөлт, чийгшил, даралт зэргээс хамаарч доторх зүйл асгарч гоожихгүй байхаар тээвэрлэхийн өмнө сайтар баглана.
- 2.2. Багласан хог хаягдлыг зориулалтын бат бэх, амархан цоорогооргүй, нух сувгүй, шингэн нэвчихгүй, таглаатай хуванцар саванд хийж гадна талд нь Хүснэгт 1-д үзүүлсний дагуу НҮБ-аас баталж гаргасан тусгай тэмдэглэгээг байрлуулна.

#### Хүснэгт 1. Тусгай хог хаягдлын баглаа боодлын тэмдэглэгээ


	4H2/Y94/S/08/MGL/001
	Жин: 94 кг

Энэхүү тэмдэглэгээ нь дараах агуулгатай:

UN	НҮБ-ын баглаа боодлын тэмдэглэгээ		
4H2	Баглаа боодлын төрлийг тодорхойлно:		
Эхний тоо (4)	Хоёр дахь үсэг (Н)	Гурав дахь тоо (2)	
1 - Торх	A - Ган	1 – Салдаг таг	
2-Төмөр торх	B – Хөнгөн цагаан	2 – Салдаггүй, бэхэлгээтэй таг	
3 - Лааз	G – Цаасан хайрцаг		
4 - Хайрцаг	H - Хуванцар		
5 - Цунх	...		

	4H2 = Салдаггүй, бэхэлгээтэй тагтай хуванцар хайрцаг
Y94	Y = II болон III бүлэгт хамаарах халдвартай зүйлс 94 = Хатуу биет: Баглаа боодол дахь зүйлсийн жин нь 94 кг
S	Зөвхөн хатуу биетэд хэрэглэнэ: S = Хатуу биет.
08	Хог хаягдлыг багласан тухайн оны сүүлийн 2 орныг илэрхийлнэ: 08 = 2008
MGL	MGL = Монгол улс
001	Хог хаягдлыг тээвэрлэж буй байгууллагын код

2.3. Халдвартай хог хаягдал тээвэрлэх савны гадна талд 100 мм x 100 мм-ээс багагүй ромбо хэлбэрийн дүрстэй, ижил өнгийн давхар хүрээтэй (дотор талын хүрээний өргөн 5 мм байна) биоаюулгүйн гурвалжин таних тэмдгийг тавьж, доод өнцөгт нь НҮБ-ын эмнэлгийн хог хаягдлыг илэрхийлсэн 25 мм-ийн өндөртэй б 6 гэсэн тоог бичнэ. Тус таних тэмдгийн дотор талд “Халдвартай эд зүйл” гэсэн тэмдэглэгээ байрлуулж болно (Зураг 1).



Зураг 1. Халдвартай хог хаягдал тээвэрлэх савны гадна талын таних тэмдэг

2.4. Хог хаягдлын савны таних тэмдэг нь уншигдахуйц ил тод, ойлгомжтой, цаг агаарын аливаа үзэгдлийн нөлөөгөөр арилахааргүй байна.

#### Гурав. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг тээвэрлэх

3.1. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг замын хөдөлгөөнд оролцох шаардлага бүрэн хангасан, тусгай таних тэмдэгтэй, аюулгүй ажиллагааны заавар хангасан, битүүмжлэгдсэн, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

3.2. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдалтай хамт өөр ачаа тээвэрлэж болохгүй.

3.3. Тээврийн хэрэгслийн жолооч нь шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслийн хангамж, тээврийн хэрэгслийн баталгаат гэрчилгээ зэргийг тээвэрлэлт хийхийн өмнө тогтмол шалгана.

3.4. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг тээвэрлэх хэрэгсэл нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:


- Жолоочийн кабин болон ачааны хэсэг хоорондоо тусгаарлагдсан байна.
- Хамгаалах хувцас хэрэглэл, цэвэрлэгээний багаж, шингэн зүйлс гоожиход авах арга хэмжээний заавар, цэвэрлэх хэрэгсэл, халдвартгуйжүүлэгч, хоосон нийлэг уут зэргийг тээврийн хэрэгсэлд байрлуулсан байна.
- Машины дотор тал нь цэвэрлэхэд хялбар, булан тохой нь хурц өнцөггүй, мөлгөр байна.

3.5. Жолооч нь гал унтраах хэрэгслийг ашиглах талаар мэдлэгтэй байх бөгөөд тээврийн хэрэгсэл дотор болон ойр орчимд тамхи татаж болохгүй.

3.6. Тээврийн хэрэгслийн дотор болон эргэн тойронд халдвартай хог хаягдал асгарсан тохиолдолд энэхүү хавсралтын 7-р хэсэгт заасны дагуу арга хэмжээ авна.


3.7. Тээврийн хэрэгсэл, чингэлэг болон хогийн савыг өдөр тутам цэвэрлэж, усаар угаан, ариутгалын бодисоор халдвартгүйтгэнэ.

3.8. Тээврийн хэрэгслийн гадна талд 250 мм x 250 мм-ээс багагүй ромбо хэлбэрийн дүрстэй, ижил өнгийн давхар хүрээтэй (дотор талын хүрээний өргөн 12,5 мм байна) биоаюулгүйн гурвалжин таних тэмдгийг тавьж, доод өнцөгт нь НҮБ-ын эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг илэрхийлсэн 25 мм-ийн өндөртэй 6 гэсэн тоог бичнэ. Тус таних тэмдгийн дотор талд "Халдвартай эд зүйл" гэсэн тэмдэглэгээ байрлуулж болно (Зураг 2).



**Зураг 2. Тээврийн хэрэгслийн таних тэмдэг**

3.9. Тээврийн хэрэгслийн урд болон ар талд галд тэсвэртэй материалаар хийгдсэн, улбар шар өнгөтэй 400 мм өргөн, 300 мм өндөр, 15 мм өргөнтэй хар өнгийн хүрээтэй анхааруулах тэмдгийг байрлуулна. Түүн дотор НҮБ-ын аюулыг илэрхийлсэн 606 болон 3291 дугаар бүхий тэмдэглэгээг 10 см-ын өндөр, 15 мм-ын өргөнтэйгээр, хар өнгөөр бичнэ (Зураг 3). Тээврийн хэрэгслийн овор хэмжээнээс хамааран урд талын анхааруулах тэмдгийн өргөнийг 300 мм, өндрийг 120 мм, хүрээний өргөнийг 10 мм болгон багасгаж болно.



**Зураг 3. Тээврийн хэрэгслийн анхааруулах тэмдэг**

3.10. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгсэлд дараах багаж хэрэгсэл байх шаардлагатай. Үүнд:

- Гал түймэр унтраах хэрэгсэл,
- Яаралтай тохиолдолд хэрэглэх засварын хэрэгсэл,
- Машины хүндийн жин, дугуйны хэмжээнд тохирсон зогсоогч (механик тоормоз),
- Цахилгаанаас хамааралгүй асдаг 2 ширхэг шар гэрэл,
- Халдвартай хог хаягдал асгарах, гоожих тохиолдолд цэвэрлэх хэрэгслүүд:
  - Бээлий, маск,
  - Шингээгч алчуур,
  - Хүрз,
  - Халдвартай хог хаягдалд зориулсан 2 ширхэг шар өнгийн уут,
  - Халваргүйтгэлийн бодис (хлор суурьтай).

#### **Дөрөв. Тээврийн хэрэгслийн баримт бичиг**

4.1. Хог хаягдалд хавсаргасан бичиг баримтыг жолооч шалгаж Хүснэгт 2-ыг бэглэнэ.

#### **Хүснэгт 2. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал тээвэрлэхэд шаардлагатай баримт бичиг**

<b>Баримт бичиг</b>	
1) Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлын бүртгэлийн маягт (Хавсралт 3-ын хүснэгт 2)	X
2) Яаралтай тусламжийн мэдээллийн хуудас	X
3) Тээврийн хэрэгслийн шалгах хуудас	X
4) Жолооны үнэмлэх	X
5) Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын гэрчилгээ	X
6) Тээврийн хэрэгслийн таних тэмдэг	X
7) Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын тусгай сургалтын гэрчилгээ	X

#### 4.2. Яаралтай тусламжийн мэдээллийн хуудас

Яаралтай тусламжийн мэдээллийн хуудас нь эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг тээвэрлэх явцад осол тохиолдвол нэн тэргүүнд авах арга хэмжээний талаарх мэдээлэл өгнө (Хүснэгт 3).

#### Хүснэгт 3. Яаралтай тусламжийн мэдээллийн хуудас

##### UN 3291 ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ХОГ ХАЯГДАЛ

###### 1. Шинж чанар

- Арьс, нүд болон амьсгалын замд аюултай
- Хүн, амьтанд халдвартараах, хөрс болон усыг бохирдуулах ноцтой эрсдэл бүхий биологийн аюултай

###### 2. Хувийн аюулгүй байдлыг хангах

- Хамгаалалтын хувцас, битүү гутал өмсөх
- Амны хаалт, бээлий, хамгаалалтын шил зүүх

###### 3. Авхь арга хэмжээ

###### 3.1 Ерөнхий

- Салхинд хийсэхээс болгоомжил. Аюултай бүсэд нэвтрэхээсээ өмнө хамгаалах хувцас, хэрэглэлийг өмсөх
- Эрсдэлтэй бүсэд олон хүн нэвтрүүлэхгүй байх
- Бохирдолд өртсөн хүн, амьтныг эмнэлгийн болон мал эмнэлгийн шинжилгээнд хамрагдахаас өмнө тусгаарлах

###### 3.2 Асгарч гоожсон тохиолдолд:

- Боломжтой бол гоожихыг зогсоох
- Боломжтой бүх аргыг хэрэглэн цоорхойг бөглөх
- Шингэнийг элс, хөрс эсвэл өөр материалд шингээх
- Хэрвээ эд зүйлс, усны эх үүсвэр, бохирын хоолойд орсон бол холбогдох албан байгууллагад мэдэгдэх

###### 3.3 Түймэр гарсан тохиолдолд:

- Гал унтраагч ашиглан гальг тургэн унтраах
- Шатаагүй эд зүйлсийг галаас холдуулах

###### 4. Аххны тусламж

- Хэрвээ нүдэнд юм орвол 15 минутаас доошгүй хугацаагаар угаах, яаралтай эмнэлгийн тусламж үзүүлэх
- Бохирлогдсон хувцсыг хурдан тайлах, арьсанд хүрсэн тохиолдолд арьсыг усаар сайтар шүршиж угаах
- Осолд өртсөн хүнд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх

###### 5. Бүтээгдэхүүнийг эргэн тээвэрлэхэд бэлдэх

- Асгарсан бүтээгдэхүүнийг битүү хайрцганд хийж лацдах

**Ослын үед холбоо барих утас: 103, 105**

#### 4.3. Тээврийн хэрэгслийн шалгах хуудас

Жолооч замд гаражын өмнө тээврийн хэрэгслийн шалгах хуудсыг бөглөнө (Хүснэгт 3). Тээвэрлэх үйл ажиллагаа дууссаны дараа жолооч шалгах хуудсыг эмнэлгийн хог хаягдлын нэгдсэн байгууламжид хүлээлгэн өгнө.

### Хүснэгт 3. Тээврийн хэрэгслийн шалгах хуудас

А. Тээврийн хэрэгслийн техникийн шалгалт	Шалгасан (5 өдөр)				
	1	2	3	4	5
1. Тоормос ажиллагаатай					
2. Дугуйн хээгүүн, тод					
3. Дугуйны хий хангалттай					
4. Толь болон цонх цэвэр					
5. Шил арчигч ажиллагаатай					
6. Гэрэл болон мэдээллийн самбар ажиллагаатай					
7. Тээврийн хэрэгслийн гадна талд гэмтэл байхгүй					
<b>В. Хамгаалах хэрэгсэл</b>					
8. ABC Гал унтраагчтай, гал унтраагч ажилладаг					
9. Аххны тусламжийн хайрцагтай					
10. Асгарч, гэмтэхэд авах арга хэмжээний багаж хэрэгсэл бүрэн: Шингээгч материал, хүрз, 2 ш шар уут, халдвартгүйтгэлийн бодис, бээлий					
11. Аюулгүй ачиж, буулгах, тээвэрлэх хэрэгслүүд					
12. Аххааруулах гурвалжин					
13. Тээврийн хэрэгслийн зурагт хуудас тод, харагдахуйц байрлалтай					
14. Аххааруулах тэмдэг харагдахуйц тод, харагдахуйц байрлалтай					
<b>С. Баримт бичиг</b>					
15. Жолоочийн үнэмлэхтэй					
16. Тээвэрлэлтийн ерөнхий мэдээллийг бүрэн гүйцэд бөглөсөн					
17. Бараа материалын тэмдэглэл бэлэн (аюултай эд зүйлсийг тээвэрлэх баримт бичиг)					
18. Баглаа боодлын таних тэмдэг, тэмдэглэгээтэй					
19. Яаралтай тусламжийн мэдээллийн хуудастай					
<b>Он сар болон гарын үсэг</b>					
1 дэх өдөр: Он сар / Гарын үсэг					
2 дахь өдөр: Он сар / Гарын үсэг					
3 дахь өдөр: Он сар / Гарын үсэг					
4 дэх өдөр: Он сар / Гарын үсэг					
5 дахь өдөр: Он сар / Гарын үсэг					

**Тусгай тэмдэглэгээ**

---



---



---

## Тав. Тээвэрлэлтийн үеийн аюулгүй үйл ажиллагаа

### 5.1. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг:

- Хог хаягдал нь үндэсний болон олон улсын дүрэм, журмын дагуу ангилагдсан эсэхийг хянах,
- Хог хаягдлыг тээвэрлэхэд хязгаарлалт байгаа эсэхийг хянах,
- Хог хаягдал нь бүрэн баглагдаж, ялгах тэмдэглэгээг наасан эсэхийг хянах,
- Хог хаягдлын холбогдох бичиг баримт бүрэн эсэхийг хянах.

### 5.2. Тээвэрлэгч байгууллагын үүрэг:

- Тээврийн хэрэгсэл нь үндэсний болон олон улсын дүрэм журмын дагуу тоноглогдсон,
- Тээвэрлэх ажилчид нь сургалтад хамрагдсан байх,
- Тээвэрлэх үйл явцыг төлөвлөсөн байх,
- Баглаж боох үйл явцыг хянах,
- Баглаа боодлын таних тэмдэг, баримт бичгийн бурдүүлэлттэй холбоотой ямар нэг алдаа илрүүлсэн бол эрүүл мэндийн байгууллага болон эмнэлгийн хог хаягдлын нэгдсэн байгууламжийн удирдлагад яаралтай мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг авахуулах

### 5.3. Жолоочид тавигдах шаардлага:

- Шаардлагатай бичиг баримт бүрэн байх,
- Зөвхөн аюулгүйн таних тэмдэг, тэмдэглэгээтэй саванд баглаж боосон хог хаягдлыг хүлээж авах,
- Холбогдох сургалтанд хамрагдсан байх,
- Ачиж, буулгах явцад баглаа боодол, хайрцгийг гэмтээхгүй байх,
- Хамгаалах хувцас хэрэглэл ашиглах,
- Заавар, зөвлөгөө, дүрэм журмыг мөрдөж, дур мэдэн ямар нэг алхам хийхгүй байх,
- Тусгай хог хаягдал бүхий баглаа боодол, уут сав, хайрцаг зэргийг нээж үзэхгүй байх,
- Хог хаягдлыг аюулгүй тээвэрлэхэд анхаарч, шатах, асгарч гоожих зэргээс урьдчилан сэргийлэх,
- Хог хаягдал асгарч гоожсон тохиолдолд зааврын дагуу аль болох түргэн цэвэрлэх,
- Тээвэрлэх болон ачиж буулгах явцад тээврийн хэрэгсэл дотор тамхи татахгүй байх,

### Зургаа. Хог хаягдлыг хүлээж авах

- 6.1. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг зөвхөн эрх бүхий байгууллага, хүмүүс хүлээж авна.
- 6.2. Хог хаягдлыг хүлээж аваходаа асгарч гоожих, хагарч гэмтэх зэрэг осол гарсан эсэхийг шалгана. Хэрвээ осол гарсан байвал 7-р бүлэгт заасны дагуу арга хэмжээ авна.
- 6.3. Хог хаягдлын ангилал болон тоо хэмжээ нь баримт бичигтэй тохирч байгаа эсэхийг шалгана.
- 6.4. Хог хаягдлын талаарх баримт бичгийг хүлээн авагчид бүрэн гүйцэд хүлээлгэн өгнө.

## Долоо. Ослын үед авах арга хэмжээ

7.1. Халдвартай эд зүйлсийн нөлөөлөлд өртсөн тохиолдолд орчин тойрныг угааж, цэвэрлэх болон халдвартгүйтгэнэ.

7.2. Халдвартай эд зүйлс арьсны бүрэн бүтэн байдлыг алдагдуулсан тохиолдолд халварлах эрсдлийг бууруулахын тулд саван болон ариутгач бодисоор сайтар угаана.

7.3. Баглаа боодлын гэмтлээс үүдэлтэй, халдвартай эд зүйлсэд өртсөн тохиолдолд эмчийн зөвлөгөө авна.

7.4. Цус асгарах болон бусад халдвартай эд зүйлсийг цэвэрлэхдээ дараах арга хэмжээг авна:

- тусгай өмсгөл, хормогч, резинэн бээлий өмсөх;
- бохирлогдсон гадаргууг ус болон угаалгын бодисоор цэвэрлэх;
- 0.05%-0.5% гипохлорт натри г.м. бодис ашиглан бохирдсон талбайг халдвартгүйтгэх;
- Хормогч, резинэн бээлий, цэвэрлэгээ хийхэд өмссөн хувцас г.м. зүйлсийг тайлан, цэвэрлэж, халдвартгүйтгэх хүртэл тусгай саванд хадгалах;
- Гараа ариутгах.

7.5. Хог хаягдал асгарч гоожсон болон осол гарсан тохиолдолд жолооч осол аваарын талаарх дэлгэрэнгүй илтгэх хуудас бичиж хог хаягдлын нэгдсэн байгууламжийн хариуцах ажилтанд өгнө.

7.6. Улирал тутамд болсон ослын талаарх илтгэх хуудсыг хог хаягдлын нэгдсэн байгууламжийн хариуцах ажилтан бэлтгэж эрх бүхий байгууллагад мэдээлнэ. Мэдээлэлд осол гэмтэлд хүргэсэн болон хор хохирол учруулсан шалтгааныг нь тогтоосон дүн шинжилгээ ба запруулсан үйл ажиллагааны талаар дурьдана.

## Найм. Тээвэрлэх үйл ажиллагааны сургалт

8.1. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг тээвэрлэхэд оролцогч бүх хүмүүс хог хаягдалтай хэрхэн харьцах, мөн холбогдох бусад үйл ажиллагааны талаарх сургалтанд хамрагдах шаардлагатай.

8.2. Тээвэрлэх үйл ажиллагааны сургалтанд хог хаягдлыг ариутгах, шатаах тоног төхөөрөмжийн оператор, ачигч, жолооч, эмнэлгийн үйлчлэгч г.м. хүмүүс хамрагдана.

8.3. Тусгай хог хаягдлын тээвэрлэлтийн үйл ажиллагааны сургалтыг тээвэрлэж буй хогны хэмжээнээс хамааруулан ерөнхий ба тусгай гэж 2 ангилна.

8.3.1. Хог хаягдлыг бага хэмжээгээр буюу 333 кг-аас доош жинтэй тээвэрлэх үед тээвэрлэх үйл ажиллагаанд оролцогчдод зориулж ерөнхий мэдлэг олгох буюу аюулгүй ажиллагааны талаарх ерөнхий сургалт зохион байгуулна. Сургалтын эцэст сургалтанд хамрагдсан тухай гэрчилгээг сургалт зохион байгуулсан байгууллагаас олгоно.

8.3.2. Хог хаягдлыг их хэмжээгээр буюу 333 кг-аас дээш жинтэй тээвэрлэх үед тээвэрлэх үйл ажиллагаанд оролцогчдод зориулж 18 хичээлтэй үндсэн курс бүхий тусгай сургалт зохион байгуулна. Энэхүү үндсэн курст дараах сэдвүүдийг зайлшгүй үзсэн байх шаардлагатай. Үүнд:

- Аюултай хог хаягдлыг тээвэрлэхэд тавигдах ерөнхий шаардлага;
- Аюул ослын төрлүүд;
- Аюултай хог хаягдлыг тээвэрлэх үед хүрээлэн буй орчныг хамгаалах талаарх мэдээлэл;
- Түгээмэл тохиолдох аюул ослоос урьдчилан сэргийлэх болон авах арга хэмжээ;
- Аюул осол гарахад авах арга хэмжээ (анхны тусламж, зам талбайн аюулгүй байдлыг хангах, хамгаалах хэрэгслийг хэрхэн ашиглах гэх мэт.);
- Тэамдэглэгээ, таних тэмдэг, зурагт хуудас болон тээврийн хэрэгслийн анхааруулах тэмдэг;
- Аюултай хог хаягдлыг тээвэрлэж буй жолоочийн хийх болон хориглох үйлдэл;
- Тээврийн хэрэгслийн техник тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа;
- Тээврийн хэрэгсэл болон хог хаягдлын саванд хамт ачихыг хориглох зүйлс;
- Аюултай эд зүйлсийг ачих, буулгах үед анхаарах зүйлс;
- Ард иргэдийн үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл;
- Тээвэрлэлтийн аюулгүй үйл ажиллагааны талаарх мэдээлэл;
- Хог хаягдлыг баглах үйл ажиллагаа

8.3.3. Тусгай сургалтанд бүрэн хамрагдан, шалгалтаа амжилттай өгсөн оролцогчдод эрх бүхий байгууллагаас олгосон A7 (105 мм × 74 мм) хэмжээтэй баталгаат гэрчилгээг олгоно (Хүснэгт 4).

#### Хүснэгт 4. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын тусгай сургалтанд хамрагдагсдад олгох гэрчилгээний загвар

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ХОГ ХАЯГДЛЫН ТУСГАЙ СУРГАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ	
Гэрчилгээний №.: _____	Овог _____ Нэр _____ Төрсөн он сар өдөр _____ Үндэстэн _____ Эзэмшигчийн гарын үсэг _____
Олгосон байгууллагын нэр: _____	Олгосон газар _____
Хүчинтэй хугацаа (он, сар, өдөр) _____	Огноо _____ Гарын үсэг _____ Сунгасан _____ хүртэл _____
	Гарын үсэг _____

8.3.4. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал тээвэрлэх тусгай сургалтанд хамрагдсанаас хойш 5 жилийн дараа 2 өдрийн дахин сургалтад хамрагдаж, шалгалт өгч гэрчилгээний хугацааг сунгуулна.